



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

(2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр)

УЛААНБААТАР ХОТ
2025 он

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 12 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Засгийн газрын тогтоол

Шийдвэрийн нэр, огноо, дугаар: Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай, 2023-12-20, Дугаар 2023_458

Зүйл, заалтын агуулга: 2. Төлөвлөгөөнд тусгагдсан, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газраас 2023-2028 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан аялал жуулчлалын урсгалыг нэмэгдүүлэх, улирлын хамаарлыг бууруулах зорилгоор өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх 2024 оны нэгдсэн төлөвлөгөөнд нийслэл хариуцах, хамтран зохион байгуулах аялал жуулчлалын 4 арга хэмжээ батлагдаж хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд: Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, үндэсний ёс зан заншил, өв уламжлалаар дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран “Мазаалай” олон улсын цас мөсний наадам, “Улаанбаатарын өвлийн наадам”, “Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль” “Бүргэдийн баяр-2024” зэрэг 4 арга хэмжээг зохион байгуулж гадаад, дотоодын нийт 127,600 гаруй хүн үзэж сонирхсон.


2025 онд Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаад, дотоодын жуулчдыг татах зорилгоор “Улаанбаатарын өвлийн наадам”, “Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль”, “Мөсөн замын суудлын авто машины уралдаан”, “Монгол нүүдэлчин өвлийн фестиваль-үндэстэн угсаатан жагсаал”, “Бүргэдийн баяр”, “Наурызын баяр”, “Монгол адуучин” нийслэлийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээн зэрэг 7 арга хэмжээг зохион байгуулж гадаад, дотоодын нийт 102,800 гаруй хүн үзэж сонирхсон.

➤ 2024 онд зохион байгуулсан өвлийн эвент арга хэмжээнүүд “Мазаалай” олон улсын цас мөсний наадам

Аялал жуулчлалын салбарын улирлын хамаарлыг бууруулах, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Соёлын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой хамтран “Мазаалай” олон улсын цас мөсний наадмыг 2024 оны 01 дүгээр сарын 14-28-ны өдрүүдэд “Скай резорт” цанын баазад зохион байгууллаа.

Монголын үндэсний бахархалт амьтан Мазаалайг хайрлан хамгаалах зорилгоор “Мазаалай мөсөн хотхон”-д 53 мазаалай, 50 метрийн урттай мөсөн гулсуур, 4000 м.кв мөсөн гулгалтын талбай, 12 метрийн өргөнтэй 18 метрийн урттай нэг цагт хамгийн олон хүн гулгах мөсөн гулсуур, Мазаалай бамбаруушнуудыг дүрсэлсэн 5 метр өндөртэй цас мөсөн баримлуудыг бүтээв.

“Мазаалай” олон улсын цас мөсний наадмын үеэр 12 метр өргөнтэй, 18 метр урттай мөсөн гулгуураар 1 цагийн дотор 408 хүн гулгаснаар Гиннесийн дээд амжилтыг тогтоож, Монгол орны өвлийн аялал жуулчлал дэлхийн газрын зурагт тэмдэглэгдсэн бөгөөд наадмын өдрүүдэд урлаг, соёл, спортын арга хэмжээг зохион байгуулж нийт 90,000 гаруй хүн “Мазаалай мөсөн хотхон”-оор үйлчлүүлэв.



“Улаанбаатарын өвлийн наадам”

Улаанбаатар хотод өвлийн болон тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, өвлийн үндэсний болон орчин үеийн экстрим спортыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Улаанбаатарын өвлийн наадам-2024” арга хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 26-28-ны өдрүүдэд “Скай резорт” цанын бааз, “Уухайн дуу” жуулчны бааз, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд тус тус зохион байгуулж, Монгол туургатны мөсөн сурын аварга шалгаруулах тэмцээн, Мөсний шагайн улсын аварга шалгаруулах тэмцээн, Параглайдингийн (уулын шүхэр) хотын аварга шалгаруулах тэмцээн, Цасны Регбигийн хотын аварга шалгаруулах тэмцээн, Снеүбоардын тэмцээн зэрэг 5 төрлийн уралдаан тэмцээнд ОХУ-ын Бүгд найрамдах Буриад улс, Бүгд найрамдах Тува улс, БНХАУ-ын ӨМӨЗО, Шинжаан Уйгур зэрэг Монгол туургатан улсаас 34, Монгол Улсын 21 аймгаас 750, Улаанбаатар хотоос 332 нийт 1,114 тамирчин оролцов.

Арга хэмжээний үеэр иргэд, сонирхогчдын дунд мөсөн сур, мөсний шагай, гэр бүлийн буухиа, олс таталтын тэмцээн зохион байгуулж, урлагийн тоглолт, open mic, параглайдингийн үзүүлбэр, шувуулахуйн үзүүлбэр, тайга нохдын үзүүлбэр, цана чарганы үйлчилгээ, хоол ундны үйлчилгээ, цаа буга, тэмээ унах үйлчилгээг зохион байгуулж арга хэмжээг гадаад, дотоодын 12,000 гаруй хүн үзэж сонирхлоо.





“Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль”

Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, хот орчмын байгалийн үзэсгэлэн, соёл, ахуй байдлыг сурталчлан таниулах, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Монголын явган алхалтын холбоо” ТББ-тай хамтран “Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль-2024” арга хэмжээг 2024 оны 03 дугаар сарын 02,03-ны өдрүүдэд зохион байгуулав.

Фестивальд “Монголын явган алхалтын холбоо”-ны салбар холбоод буюу нийслэлийн 9 дүүрэг, Дархан-Уул, Орхон, Төв, Хэнтий, Дорноговь, Өмнөговь, Сэлэнгэ, Баян-Өлгий, Увс зэрэг 10 аймгийн явган алхалтын клубүүдийн 600 гаруй алхагчид оролцож, 2024 оны 03 дугаар сарын 02-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс Скай резорт цанын бааз буюу “Туул өртөө” хүртэл 10км, 2024 оны 03 дугаар сарын 03-ны өдөр Олон улсын хүүхдийн “Найрамдал” зуслангаас “Жавхлант өртөө” хүртэл 10км маршрутаар алхалт хийж, оролцогчдын дунд мөсөн шагайн тэмцээн, олс таталтын тэмцээн зохион байгууллаа.



“Бүргэдийн баяр”

Казах үндэстэн ястны ёс заншил, өв уламжлал, соёлыг сурталчлан таниулах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор 18 дахь жилдээ “Бүргэдийн баяр” арга

хэмжээг 2024 оны 03 дугаар сарын 09,10-ны өдрүүдэд “Чингис хааны хүрээ” аялал жуулчлалын цогцолборт зохион байгуулав.

Арга хэмжээнд Баян-Өлгий, Төв аймгуудаас 21 шилдэг бүргэдчинийг оролцуулан бүргэдтэй парад, бүргэдүүдийг танилцуулж алдаршуулах арга хэмжээ болон бүргэдчидийн дунд бүргэдээр шырга (хиймэл ан) бариулах тэмцээн, бүргэдээ хэрхэн сайн сургасан байдлыг шалгаруулах тэмцээн, Казак үндэсний тоглоом көкбар (тулам булаалдах) тэмцээн, зоос шүүрэх тэмцээнүүдийг зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр “Морьтон баатруудын шоу тоглолт”, “Тайга анч нохдын үзүүлбэр”, шүхрийн үзүүлбэр болон тойром бүжиг, цаа буга, тэмээ, морь унах, бүргэд шувуу болон тэмээтэй зураг даруулах болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулж “Бүргэдийн баяр-2024” арга хэмжээг гадаад, дотоодын 25,000 гаруй хүн үзэж сонирхлоо.



➤ 2025 онд зохион байгуулсан эвент арга хэмжээнүүд

“Улаанбаатарын өвлийн наадам-2025” арга хэмжээ

“Улаанбаатарын өвлийн наадам-2025” арга хэмжээг 2025 оны 02 дугаар сарын 15,16-ны өдрүүдэд “Скай резорт” цанын баазад зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр Мөсөн сурын олон улсын аварга шалгаруулах тэмцээн, Мөсний шагайн улсын аварга шалгаруулах тэмцээн, Параглайдийнгийн (уулын шүхэр) хотын аварга шалгаруулах тэмцээн, Цасны Регбигийн хотын аварга шалгаруулах тэмцээн, Снөүбоардын хотын аварга шалгаруулах, Цанын хотын аварга шалгаруулах тэмцээн, Кёрлингийн хотын аварга шалгаруулах тэмцээн зэрэг 7 төрлийн уралдаан тэмцээнд ОХУ-ын Бүгд найрамдах Буриад улс, Бүгд найрамдах Тува улс, Бүгд найрамдах Халимаг улс, БНХАУ-ын ӨМӨЗО, Шинжаан Уйгур зэрэг Монгол туургатан улсаас 36, Монгол Улсын 21 аймаг болон Улаанбаатар хотоос 1222 нийт 1258 тамирчин оролцов. “Улаанбаатарын өвлийн наадам-2025” арга хэмжээний үеэр иргэд, сонирхогчдын дунд мөсөн сурын тэмцээн, мөсний шагайн тэмцээн, олс таталт, мөсөн хана авиралтын тэмцээн зохион байгуулж, мөн урлагийн тоглолт, open mic, параглайдийнгийн

үзүүлбэр, шувуулахуйн үзүүлбэр, банхар нохдын үзүүлбэр, цана чарганы үйлчилгээ, хоол ундны үйлчилгээ, цаа буга, тэмээ унах үйлчилгээг зохион байгуулж арга хэмжээг гадаад, дотоодын 13,000 гаруй хүн үзэж сонирхлоо.



“Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль-2025” арга хэмжээ

Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах, хот орчмын байгалийн үзэсгэлэн, соёл, ахуй байдлыг сурталчлан таниулах, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Монголын явган алхалтын холбоо”, “Монгол Олле” нийгэмлэгтэй хамтран “Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль-2025” арга хэмжээг 2025 оны 02 дугаар сарын 15,16-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Фестивальд ОХУ, БНХАУ, БНСУ, Япон улс, БН Казакстан Улс зэрэг 5 улсаас 56 алхагч, “Монголын явган алхалтын холбоо”-ны салбар холбоод буюу нийслэлийн 9 дүүрэг, Дорнод, Өмнөговь, Дорноговь, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв зэрэг 11 явган алхалтын клубүүдийн 300 гаруй алхагчид оролцож 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Олон улсын хүүхдийн “Найрамдал” зуслангаас “Жавхлант өртөө” хүртэл 10км, 2025 оны 02 дугаар сарын 16-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс Скай резорт цанын бааз буюу “Туул

өртөө” хүртэл 10км маршрутаар алхалт хийж, оролцогчдын дунд мөсөн шагайн тэмцээн, олс таталтын тэмцээн зохион байгуулсан.



“Мөсөн замын суудлын авто машины уралдаан-2025” арга хэмжээ

1.1.3.Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр нэмэгдүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах, иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Монголын Автомашин Мотоциклын Холбоотой хамтран “Мөсөн замын суудлын авто машины уралдаан-2025” арга хэмжээг 2025 оны 02 дугаар сарын 16, 23-ны өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Хун нуур”-т амжилттай зохион байгууллаа. “Мөсөн замын суудлын авто машины уралдаан-2025” арга хэмжээнд мэргэжлийн авто спортын 50 гаруй тамирчид 2 өдрийн турш өрсөлдөж шилдгүүдээ тодруулж, арга хэмжээг гадаад, дотоодын нийт 1500 гаруй хүн үзэж сонирхлоо.




“Монгол үндэстэн угсаатан жагсаал”

“Монголд зочлох жил”-ийн хүрээнд өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, соёлын өвөө таниулан сурталчлах зорилгоор Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам,

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Засгийн газрын тохируулагч агентлаг Соёл, урлагийн газар хамтран “Монгол нүүдэлчин өвлийн фестиваль”-ийг 2025 оны 02 дугаар сарын 16-22-ны өдрүүдэд “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн”-д зохион байгуулсан. Фестивалийн хүрээнд “Монгол үндэстэн угсаатан жагсаал”-ыг Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Улсын хүүхэд, залуучуудын театр, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газартай хамтран 2025 оны 02 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулж жагсаалд мэргэжлийн урлагийн байгууллагуудын уран бүтээлчид, нийслэлийн 6 дүүргийн нийт 800 гаруй хүн оролцлоо.

“Монгол үндэстэн угсаатан жагсаал”-д оролцогчдоос шилдэг дүүрэг, сайхан дээлтэй хос, сайхан дээлтэй эрэгтэй оролцогч, сайхан дээлтэй эмэгтэй оролцогч зэрэг 4 номинациар шилдгүүдийг тодруулав.




“Бүргэдийн баяр” арга хэмжээ

Казах үндэстэн ястны ёс заншил, өв уламжлал, соёлыг сурталчлан таниулах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, өвлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх ззорилгоор “Бүргэдийн баяр” арга хэмжээг 2025 оны 03 дугаар сарын 08,09-ний өдрүүдэд “Чингис хааны хүрээ” аялал жуулчлалын цогцолборт зохион байгуулав.

Арга хэмжээнд Бүгд найрамдах Казакстан Улсаас 2 бүргэдчин, Бүгд найрамдах Киргиз Улсаас 2 бүргэдчин, Баян-Өлгий аймгаас 20 бүргэдчин, Сэлэнгэ, Төв аймгаас тус бүр 1 нийт 26 бүргэдчид оролцлоо.

Арга хэмжээний үеэр бүргэдтэй парад, бүргэдүүдийг танилцуулж алдаршуулах арга хэмжээ болон бүргэдчидийн дунд бүргэдээр шырга (хиймэл ан) бариулах тэмцээн, бүргэдээ хэрхэн сайн сургасан байдлыг шалгаруулах тэмцээн, Казак үндэсний тоглоом көкбар (тулам булаалдах) тэмцээн, зоос шүүрэх тэмцээнүүдийг зохион байгууллаа. Мөн “Морьтон баатруудын шоу тоглолт”, “Банхар, тайга анч нохдын үзүүлбэр”, шүхрийн үзүүлбэр болон тойром бүжиг, цаа буга, тэмээ, морь унах, бүргэд шувуу болон тэмээтэй зураг даруулах болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчийн үзэсгэлэн худалдаа, урлагийн тоглолт зэрэг арга хэмжээг зохион байгуулж гадаад, дотоодын нийт 20,000 гаруй хүн үзэж сонирхлоо



“Наурызын баяр-2025” арга хэмжээ

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Баян-Өлгий аймгийн нутгийн зөвлөлтэй хамтран “Наурызын баяр-2025” арга хэмжээг 2025 оны 03 дугаар сарын 22-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгууллаа.


Арга хэмжээний үеэр Казак түмний уламжлалт гэр үзэсгэлэн, жижиг дунд үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн худалдаа, казак бөхийн үзүүлэх барилдаан, Казак үндэсний Алты бахан /савлуур/, күрес бөхийн үзүүлэх барилдаан, Казак үндэсний хоол, Шувуулахуйн үзүүлбэр, Монгол банхар үзэсгэлэн зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж арга хэмжээг гадаад, дотоодын нийт 20,000 гаруй хүн үзэж сонирхлоо.



“Монгол адуучин” нийслэлийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээн

Монголын үндэсний соёл, ёс заншлаа хадгалан хамгаалах, адуун соёлоо дээдлэх, хөгжүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах, аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгох зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, “Монгол адуучдын холбоо” төрийн бус байгууллагатай хамтран “Монгол адуучин” нийслэлийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээнийг 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Хүй 7 хутагт зохион байгуулав.

“Монгол адуучин” нийслэлийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээнийг адуучин, морьтой саад сүлжих, адуучин магтаал, сайхан уургын морь, марзай гийнгоо зэрэг 5 төрлөөр зохион байгуулж тэмцээнд 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн 130 адуучин залуучууд оролцож, арга хэмжээг гадаад, дотоодын нийт 3000 гаруй хүн үзэж сонирхлоо.



Шийдвэрийн нэр, огноо, дугаар: Жуулчдын урсгалыг нэмэгдүүлж, дөрвөн улирлын турш жуулчин хүлээн авах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2024-11-27, Дугаар 2024_191_01, Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

Зүйл, заалтын агуулга: 1.1. Өвлийн улиралд нислэгийн тийзийн үнийг 40 хүртэл хувь хөнгөлөх асуудлыг судалж шийдвэрлэх, орон нутгийн нислэгийн давтамжийг нэмэгдүүлж, цагийн хуваарийг тогтвортой мөрдүүлж ажиллахыг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайханд, "Чингис хаан" олон улсын нисэх буудлын чиглэлд тогтсон хуваарийн дагуу нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатарт;

Биелэлт: Жуулчин тээврийн үйлчилгээг хөгжүүлэх, гадаад, дотоодын иргэд, жуулчдын аюулгүй байдлыг хангасан зорчих үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор жуулчин тосох, угтах үйлчилгээнд 45 хүний суудалтай олон улсын стандартын шаардлага хангасан 7 автобусыг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2 маршрутаар тогтсон хуваарийн дагуу өдөр бүр “Х:19 Сүхбаатарын талбай - Чингис хаан ОУНБ”, “Х:20 5 шар - Чингис хаан” ОУНБ” гэсэн 2 чиглэлд, 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс шөнийн нийтийн тээврийн үйлчилгээг 1 чиглэл буюу ШҮ:4 Сүхбаатарын талбай - Чингис хаан ОУНБ” нэвтрүүлж, гадаад хэлний мэдлэгтэй 14 хөтөч-тайлбарлагчийг тогтмол ажиллуулж байна.



ТОМ ХҮН: 10.0007
ХҮҮХЭД 5.0007

ЧИГЛЭЛ: Х:20
ЧИНГИС ХААН ОУНБ-ТАВАН ШАР

Таван шар - Чингис Хаан ОУНБ руу

Хөдлөх	Ирэх
06:15	07:05
06:55	07:45
07:35	08:25
08:15	09:05
08:55	09:45
09:35	10:25
10:15	11:05
11:05	11:55
11:45	12:35
12:25	13:15
13:05	13:55
13:45	14:35
14:25	15:15
15:05	15:55
15:45	16:35
16:35	17:25
17:15	18:05
17:55	18:45
18:35	19:25
19:15	20:05
19:55	20:45
20:35	21:25
21:15	22:05

Чингис Хаан ОУНБ - Таван шар

Хөдлөх	Ирэх
07:15	08:05
07:55	08:45
08:35	09:25
09:15	10:05
10:05	10:55
10:45	11:35
11:25	12:15
12:05	12:55
12:45	13:35
13:25	14:15
14:05	14:55
14:45	15:35
15:35	16:25
16:15	17:05
16:55	17:45
17:35	18:25
18:15	19:05
18:55	19:45
19:35	20:25
20:15	21:05
20:55	21:45
21:35	22:25
22:15	23:05



ТОМ ХҮН: 15.0007
ХҮҮХЭД 7.0007

ЧИГЛЭЛ: Х:19
ЧИНГИС ХААН ОУНБ-СҮХБААТАРЫН ТАЛБАЙ

Сүхбаатарын талбай - Чингис Хаан ОУНБ

Хөдлөх	Ирэх
06:15	07:25
06:55	08:05
07:35	08:45
08:15	09:25
08:55	10:05
09:35	10:45
10:15	11:25
10:55	12:05
11:55	13:05
12:25	13:35
13:05	14:15
13:45	14:55
14:35	15:45
15:05	16:15
15:45	16:55
16:25	17:35
17:25	18:35
17:55	19:05
18:35	19:45
19:15	20:25
20:05	21:15
20:35	21:45

Чингис Хаан ОУНБ - Сүхбаатарын талбай


Хөдлөх	Ирэх
07:35	08:45
08:15	09:25
08:55	10:05
09:35	10:45
10:35	11:45
11:05	12:15
11:45	12:55
12:25	13:35
13:15	14:25
13:45	14:55
14:25	15:35
15:05	16:15
16:05	17:15
16:35	17:45
17:15	18:25
17:55	19:05
18:45	19:55
19:15	20:25
19:55	21:05
20:35	21:45
21:25	22:35
21:55	23:05



Зүйл, заалтын агуулга: 2.3. Аялал жуулчлалын нэгдсэн цаглабрыг боловсруулж, улирлын онцлогийг харгалзан салбарын олон улсын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, урлаг, соёл, спортын зарим арга хэмжээг жил бүрийн 10 дугаар сараас дараа жилийн 4 дүгээр сар хүртэл хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт.


Биелэлт: “Монголд зочлох жил”-ийн хүрээнд Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, үндэсний ёс заншил, өв уламжлалаар дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах, урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор 2025 онд зохион байгуулах аялал жуулчлалын арга хэмжээний цаглабрыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд хүргүүлж, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанд “Монгол Улсад 2025 онд зохион байгуулах аялал жуулчлалын арга хэмжээний нэгдсэн цаглабар” танилцуулагдсан.

Нэгдсэн цаглабарт Улаанбаатар хотод 2025 оны 1, 4 дүгээр улиралд зохион байгуулах 10 үзэсгэлэн, арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд: 2025 оны 04 дүгээр сар хүрэлх хугацаанд “Улаанбаатарын өвлийн наадам”, “Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль”, “Мөсөн замын суудлын авто машины уралдаан”, “Монгол нүүдэлчин өвлийн фестиваль-үндэстэн угсаатан жагсаал”, “Бүргэдийн баяр”, “Наурызын баяр”, “Монгол адуучин” нийслэлийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээн зэрэг 7 арга хэмжээг зохион байгууллаа.



Зүйл, заалтын агуулга: 5. Жуулчдад үйлчлэх стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг зохих байршилд байгуулж, байнгын ажиллагаатай байх нөхцөлийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

Биелэлт: Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн гудамж, талбайд стандартын шаардлага хангасан байнгын үйл ажиллагаатай 19 ариун цэврийн байгууламж (нийтийн бие засах газар) иргэдэд, жуулчдад үнэ төлбөргүй үйлчилж байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 2 байршилд 24 цагийн, 17 байршилд 08:00-20:00 цагийн хооронд үйлчилгээ үзүүлж, нийтийн бие засах газруудын арчлалт, засвар, үйлчилгээг дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар хариуцан ажиллаж байна. Шинээр 2024 онд Богд хан уулын Дугуйцагаан орчимд нийтийн бие засах газар байгуулж, 2025 онд Налайх дүүргийн Соёлын ордны арын талбайд байгуулж ашиглалтад оруулсан. Жуулчдад зориулсан арга хэмжээнүүдийн үеэр стандартын шаардлага хангасан зөөврийн био ОО-уудыг нэмэлтээр байршуулж ажилласан.



ДАРГА

D. Battsukh

Д.БАТСҮХ

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТАЙЛАН, ТОГТООЛ ШИЙДВЭР,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН *O. Nyambat* О.НЯМБАТ